



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/13

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Жаргалант сумын Бугат багийн нутаг дэвсгэрт “Залаа Алтай” ХХК-ийн барьсан 56 айлын орон сууцны барилга угсралтын ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Т.Жаргалсайхан - Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд: З.Өмиртай - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Д.Нямтулга - Мэргэжлийн хяналтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч

Н.Цацралцэцэг - Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч

Б.Эрдэнэцэцэг - Мэргэжлийн хяналтын газрын эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч

Б.Бат-Оюун - Мэргэжлийн хяналтын газрын харилцаа холбооны хяналтын улсын байцаагч

Т.Бямбатөмөр - “Ховд дулаан станц” төрийн өмчит хувьцаат компаний ерөнхий инженер

Г.Ганжаргал - Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч

- Д.Алтанхуяг - “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ийн ерөнхий инженер
- М.Нансалмаа - “Шим-Ус” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий инженер
- Н.Ням-Эрдэнэ - “Ховд цахилгаан түгээх сүлжээ” ХХК-ийн ерөнхий инженер
- Л.Батбаяр - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
- Ж.Сүхбаатар - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүн
- Ц.Цолмонбаатар - Стандарт, хэмжил зүйн хэлтсийн салбар сан хариуцсан мэргэжилтэн
- Т.Насантогтох - “Аксиом констракшн” ХХК-ийн захирал
- Ч.Нямцэцэг - “Залаа Алтай” ХХК-ийн захирал
- С.Батдорж - Аймгийн Архивын тасгийн дарга

Нарийн бичгийн

дарга: Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

2. Орон сууцны барилга угсралтын ажлыг зураг, төсвийн дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргаж хүлээн эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ